


МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМАНД

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 5 дугаар сарын 2-ны өдрийн хуралдааны 20 дугаар тэмдэглэлд:

“ХХ.4. “Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл”-ийг хэрэгжүүлэх хуулийн этгээд байгуулах тухай асуудлыг Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ Засгийн газрын гишүүдэд танилцуулав.

Үүнтэй холбогдуулан “Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл”-ийг хэрэгжүүлэх хамтарсан хуулийн этгээдийн монголын талд ногдох хувийг эзэмших төрийн өмчит компани байгуулах асуудлыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж, Засгийн газрын хуралдаанд оруулж шийдвэрлүүлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т даалгав.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР